



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 26 өдөр

Дугаар А/63

Хужирт сум

Хоршоог хөгжүүлэх сангаас
зээл олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А/361 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан "Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-ын 3.4.2, 3.4.3, 3.4.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖИЛАХ нь:

1. "Хоршоог хөгжүүлэх сан"-ийн төсөл сонгон шалгаруулах хорооны 2023 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 01 дүгээр хуралдааны шийдвэрийн дагуу "Хоршоог хөгжүүлэх сан"-ийн зээлийн эргэн төлөлтөөс төвлөрсөн 75,000,000 (далан таван сая) төгрөгийг шалгарсан 4 төсөлд хавсралтаар олгосугай.

2. Төсөлд олгогдох хөрөнгийг тус сангаас зарцуулж, орлого, зарлагын дүн болон зарцуулалтын тайланг улирал, жилээр гаргаж дүнг танилцуулж байхыг Санхүүгийн албаны дарга (Д.Уранчимэг)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ